



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 02

Урт

Ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2020 оны ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, Иргэний танхимын ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Хурлын дарга /Б.Отгонбаяр/, Тэргүүлэгчид, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР



Гурвантэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
2020 оны 22 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

**ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2020 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Урт.

2020 он

№	Хийгдэх ажлууд	Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар										Хариуцах эзэн					
		1	2	3	4	5	6	7	8	9	10		11	12			
1.	ИТХурлын үзэл баримтлал, Засаг даргын Үндсэн чиглэл, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжилт, үр дүнг нь иргэдэд байнга мэдээлэх, үнэлэлт дүгнэлт өгөх																ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид
2.	ИТХурлын хороодын ажлын төлөвлөгөөг баталж, удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх																ИТХ-ын хороод
3.	2020 оныг "Залуучуудын хөгжлийг дэмжих жил" болгон зарлах, Залуучуудын чуулга уулзалт, урлаг спортын их наадмыг зохион байгуулах /тусгай хөтөлбөр төлөвлөгөөгөөр/																ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид
4.	Сумын ИТХ-ын төлөөлөгчдийг сонгогдсон тойрогт нь ажиллуулах, багийн хурал, мал тооллого болон нэгдсэн арга хэмжээнүүдэд оролцуулж хийсэн ажлын үр дүнг тооцож ажиллах																ИТХ-ын дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга
5.	Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх, хариуцлагын тогтолцоог сайжруулахад анхаарч, байгууллага, мэргэжилтнүүдийн тайланг хэлэлцэж зөвлөмж өгөх /төлөвлөгөө гаргах/																ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид
6.	Сумын Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг аймгийн болон Төрийн дээд шагналд тодорхойлох																ИТХ-ын дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга
7.	Сум орон нутгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг ИТХурлын нэрэмжит шагналаар шагнаана.																ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид
8.	Төрийн байгууллагуудын хамтарсан "Нээлтэй хаалганы өдөрлөг"-ийг зохион байгуулах																Засаг дарга, ЗДТГ, албан байгууллагын дарга эрхлэгч нар

9.	Улаан загалмайн ажлыг иргэдэд сурталчлах, сайн үйлсийн аян зохион байгуулах, улаан загалмайн татварыг төвлөрүүлэх																								ИТХ-ын ажлын алба	
10.	Амьдрах ухааны чиглэлээр сургалтуудыг зохион байгуулах																									ИТХ-ын дарга, ИТХ-ын ажлын алба
11.	Хэлмэгдсэдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан арга хэмжээ зохион байгуулах																									ИТХ-ын дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга

Хоёр. Нийгмийн бодлогын хүрээнд

1.	Боловсролыг дэмжих жилийн хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран ажил зохион байгуулах																											ИТХ-ын дарга, ИТХ-ын ажлын алба, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
2.	Гэр бүлийг дэмжих жилийн хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран ажил зохион байгуулах																											ИТХ-ын дарга, ИТХ-ын ажлын алба, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
3.	Иргэд, хүүхэд залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах																											ИТХ-ын дарга
4.	Малчдын урлагийн наадмыг зохион байгуулахад хамтран ажиллах																											ИТХ-ын дарга, ажлын алба
5.	Тусламж дэмжлэг шаардлагатай иргэдийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч ажиллах																											ИТХ-ын дарга
6.	Ахлах ангийн сурагчдын дунд илтгэлийн уралдаан зохион байгуулах, дүгнэх																											ИТХ-ын ажлын алба

Гурав.Сургалт, Сурталчилгааны талаар.

1.	Сумын ИТХурал болон ЗДТГазраас 2016-2019 онд хийсэн ажлын тайлангийн товхимолыг бэлтгэж малчид иргэдэд хүргэх																												ИТХурал, ЗДТГазар
2.	Хууль сурталчлах зорилгоор хуулиудын заалтаар анхааруулга, санамиж, зөвлөмж хийж иргэдэд сурталчлах																												ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, БИНХ-ын дарга нар
3.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор албан байгууллага, иргэдийн дунд хууль сурталчлах "Иргэн ба хууль" арга хэмжээг зохион байгуулах																												ИТХ-ын дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
4.	Иргэний танхимын үйл ажиллагааг тогтмолжуулж,																												ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид,

хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах	ИТХ-ын ажлын алба
5. УИХ-ын даргын ивээл дор жил бүр уламжлал болгон зохион байгуулагдаг сумын Шатрын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах	ИТХ-ын ажлын алба

Дөрөв. Хяналт шалгалт, сахилга дэг журмын талаар.

1. Уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд хяналт тавьж, хамгарч ажиллах																			Төлөөлөгчид, Тэргүүлэгчид, Уул уурхай, Дэд бүтцийн хороо
2. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллах																			ИТХ-ын дарга, Эдийн засаг, өмч, төсөв санхүүгийн хороо
3. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажилд хяналт тавих																			Эдийн засаг, өмч, төсөв санхүүгийн хороо
4. Орон нутгийн хөгжлийн сан болон бусад хөрөнгө оруулалтын ажлуудад хяналт тавих																			Тэргүүлэгчид, уул уурхай, дэд бүтцийн хороо, Орон нутгийн хөгжлийн сангийн хяналтын зөвлөл
5. Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас гарсан шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих																			ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо, ажлын алба
6. Сумын Засаг даргын үйл жилийн хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх																			ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо
7. Амьжиргааг дэмжих зөвлөлийн ажилд хяналт тавих																			ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД

Гурвантэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
2020 оны 8 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт

**ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДЭРГЭДЭХ
ИРГЭНИЙ ТАНХИМААС 2020 ОНД ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2020 он

Урт.

Хийгдэх ажил	Хугацаа /сар/												Хариуцах албан тушаалтан, байгууллага		
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12			
1 Сургалт зөвлөгөөн, хэлэлцүүлэг, хурлын ажил зохион явуулахад танхим байрыг засаж бэлэн болгох															Иргэний танхим хариуцсан ажилтан
2 Багийн хурал иргэдийн нийтийн хуралд оролцох															Иргэний танхим хариуцсан ажилтан
3 "Өглөөний цай" уулзалтыг зохион байгуулах															ИТХурал, Иргэний танхим хариуцсан ажилтан
4 Хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах															Иргэний танхим хариуцсан ажилтан
5 ИТХурал, ЗДТГазраас явуулсан ажил арга хэмжээг иргэдэд цахимаар цаг алдалгүй хүргэж ажиллах															Иргэний танхим хариуцсан ажилтан
6 ИТХурлаас гарах шийдвэрийн төсөлд иргэдийн саналыг тусгаж ажиллах															Иргэний танхим хариуцсан ажилтан
7 Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх хөрөнгө оруулалтын саналыг иргэдээс авч ажиллах															Иргэний танхим хариуцсан ажилтан

8	Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой сургалтуудыг зохион байгуулах		Иргэний танхим хариуцсан ажилтан
9	Иргэний танхимд хуулийн булан байгуулж, гарын авлага, сурталчилгааны материалыг иргэний танхимаар дамжуулан иргэдэд хүргэх		Иргэний танхим хариуцсан ажилтан

_____ 000 _____



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 03

Урт

Багуудын хурал, өдөрлөгийн тов
тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. 2020 онд багуудын Иргэдийн Нийтийн хурал, өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулах хуваарийг хавсралтаар баталсугай.
2. Хуваарийн дагуу багийн Иргэдийн Нийтийн Хурал, өдөрлөгийн арга хэмжээний зарыг иргэдэд хүргэж хурал, өдөрлөгийн арга хэмжээг чанартай зохион байгуулахыг багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

Гурвантэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
2020 оны 4 дүгээр тоот тогтоолын хавсралт

БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ, ӨДӨРЛӨГИЙН 2020 ОНЫ ХУВААРЬ

2020

Урт

№	Багийн нэр	Хугацаа	Болох газар	Хугацаа	Болох газар	Хугацаа	Болох газар	Хугацаа	Болох газар
		1 дүгээр улирал		2 дугаар улирал		3 дугаар улирал		4 дүгээр улирал	
1	Гоёот баг	2020.01.30	Сумын төв	2020.05.25	Багийн төв	2020.08.03	Багийн төв	2020.11.28	Сумын төв
2	Баясах баг	2020.01.30	Сумын төв	2020.05.26	Багийн төв	2020.08.04	Багийн төв	2020.11.28	Сумын төв
3	Тост баг	2020.01.31	Сумын төв	2020.05.27	Багийн төв	2020.08.05	Багийн төв	2020.11.29	Сумын төв
4	Урт баг	2020.01.31	Сумын төв	2020.05.28	Сумын төв	2020.08.06	Сумын төв	2020.11.29	Сумын төв
5	Бага-Овоо баг	2020.01.29	Сумын төв	2020.05.29	Багийн төв	2020.08.07	Багийн төв	2020.11.30	Сумын төв



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 04

Урт

“Залуучуудын хөгжлийг дэмжих жил”
болгон зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гурвантэс сумын хэмжээнд 2020 оныг “Залуучуудын хөгжлийг дэмжих жил” болгон зарласугай.

2. “Залуучуудын хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд орон нутгийн түвшинд залуучуудад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулж хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг сумын Засаг дарга /О.Баттогтох/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР